

**"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ-ЫН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 01

Улаанбаатар хот

№	Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая. төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8	9
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:								
1.1. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл								
Зорилт: 4.1.1 Нийслэлийн өмчийн хөрөнгийг эргэлтэд оруулж, өмч ашиглалтын үр өгөөжийн нэмэгдүүлсэн байна.								
1	1.1.1	1.1.1.3 Байгууллагын өмчид бүртгэлтэй эд хөрөнгийг түрээс үйлчилгээнд гаргаж төсвийн орлого бүрдүүлнэ.		Өмчийн түрээсийн орлого	145,0	235,2	Тайлант хугацаанд нийслэлийн төсөвт 235,2 сая төгрөгийн орлого бүрдүүлэх төлөвлөгөөнөөс III-р улирлын байдлаар тайлант хугацаанд 343,692,300 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан.	100%
Зорилт: 4.1.3 Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулсан байна.								
2	1.1.2	1.1.2.1 Төсвийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, батлагдсан төсвийн хүрээнд сар, улирлын хуваарийн саналыг бэлтгэж санхүүгийн сахилга батыг сайжруулж ажиллана.		Нийт батлагдсан төсөв	1,151,3	1,817,5	Төсвийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж 2025 оны III-р улирлын байдлаар 61,806,893 сая төгрөгийн хэмнэлт үүсгэн ажилласан. Санхүүгийн сахилга бат сайжруулж, төсвийн жилд өр, авлага үүсгэхгүй, төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажилласан.	100%
1.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр								
Зорилт: 2.1.8 Үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлж, нийслэлийн иргэдийн дунд зохион байгуулах уралдаан, тэмцээн наадмын төрлийг нэмж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэж, суурь үзүүлэлтийг 5 хувиар ахиулна.								
3	1.2.1	Үндэсний спортын холбоод, бусад спортын холбоодоос Хүй долоон худагт зохион байгуулах үйл ажиллагаануудын тохижилт,		Арга хэмжээний бэлэн байдлыг	4	6	2025.02.21-н, 03.13-нд Монголын морин тойруулга, богино зайн уралдаан, уяачдын холбооны Mongolian breeders cup-2025 тэмцээн	100%

[illegible]

1	2	3	4	5	6	7	8	9
5	1.2.3	5.1.1 Хариуцсан чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлнэ.		Хэрэгжилтийн хувь	-	100	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар бүлгийн 5.1.1 -н арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын дотоод үнэлгээг зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу байгууллагын дотоод үнэлгээг ажлын хэсэг байгуулан, үнэлгээний цахим маягтыг ашиглан байгууллагын мэдээллийг, дотоод үнэлгээг үнэн зөв, бодит мэдээлэлд тулгуурлан, чанартай үр дүнтэй зохион байгуулж 2025.04.25-ны өдрийн дотор тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газарт албан бичгээр хүргүүлсэн.	100%
6	1.2.4	5.1.4 Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.		Хэрэгжилтийн хувь	-	100	Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний №43 дугаартай тогтоолын хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", "Үнэлгээ хийх журам", "Хяналт-шинжилгээ хийх журам" гэсэн шинээр батлагдсан журмуудыг судалж хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажилласан.	100%
7	1.2.5	Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.		Бүрдүүлсэн статистик мэдээллийн сангийн тоо	1	2	2025 оны 1, 2, 3 дугаар улиралд Нээлттэй мэдээллийн "Shilen.gov.mn" системд хариуцсан чиг үүргийн тухай бүр боловсруулан тайлагнаж 91%-н үнэлгээтэй ажилласан.	90%

1	2	3	4	5	6	7	8	9
Зорилт: 5.1.14.Нийслэлийн хэмжээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангуулах, төрийн албан хаагчдыг авлигын эрсдэл, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.								
		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.		Төлөвлөгөөний биелэлтийн хувь	-	2	2025 оны 05 дугаар сарын 02-ны А/14 дүгээр тушаалаар "Ёс зүйн дэд хороо"-г шинэчлэн байгуулсан. Ёс зүйн дэд хороо нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 зорилт 15 арга хэмжээтэйгээр төлөвлөн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Ёс зүйн дэд хороонд 2025 оны 05 дугаар сард албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой 1 өргөдөл, гомдол мэдээлэл ирсэнийг холбогдох хууль дүрмийн дагуу шийдвэрлэсэн.	100%
8	1.2.6							
9	1.2.7	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030 он)-г хэрэгжүүлж, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.		Хамтран ажилласан байгууллагын тоо	-	2	Газрын хэмжээнд Хөрөнгө орлогын мэдүүлэг өгөх үүрэгтэй Газрын дарга, Ерөнхий нягтлан бодогч нар ХОМ-ийг хуулийн хугацаанд багтаан мэдүүлсэн. Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
Зорилт: 5.2 Технологийн дэвшилтэт шийдлүүдийг ашиглан төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай чирэгдэлгүй, цогц байдлаар хүргэж, ил тод нээлттэй байдлыг хангасан цахим засаглалыг хэрэгжүүлнэ.								
10	1.2.8	5.2.9 Байгууллагын архивт хадгалагдаж буй цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлнэ.		Цахимжсан баримтын тоо	2	2	2024 оны газрын даргын А-25, Б-78 ширхэг тушаалыг Edoc системийн Archive Edoc-д PDF хэлбэрээр бүртгэж улсын бүртгэгчээр хянан баталгаажуулсан.	100%
Зорилт: 5.2.4.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулах.								
11	1.2.9	"Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай" хуулийн хэрэгжилтийг хангаж, газрын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, зохион байгуулалт, арга		Нийтэд ил тод байршуулсан мэдээ, ан мэдээ,	80	100	Эхний хагас жилийн байдлаар "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай" хуулийн хэрэгжилтийг хангаж байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны талаарх 80 төрлийн	90%

1	2	3	4	5	6	7	8	9
		хэмжээний талаарх мэдээ, мэдээллүүдийг ил тод, нээлттэй нийтэд мэдээлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулна.		мэдээллийн тоо			мэдээ, мэдээллийг mnts.ub.gov.mn сайт болон Монгол наадам цогцолбор цахим хаягаар сурталчлан ажилласан.	
Зорилт: 1.3. Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө								
12	1.3.1	MNS ISO 9001:2016 - чанарын менежментийн тогтолцооны стандартын нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.		Хэрэгжилтийн хувь	-	100	MNS ISO 9001:2016 - чанарын менежментийн тогтолцооны стандартын нэвтрүүлэх сургалтанд 2 албан хаагч суулгахаар төлөвлөж, стандартын нэвтрүүлж ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн.	50%
13	1.3.2	Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулна, хэрэгжилтийг хангаж ажиллана.		Хэрэгжилтийн хувь	-	100	Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг газрын даргын тушаалаар байгуулсан. Төлөвлөгөөг боловсруулах ажил 90%-тай явагдаж байна.	70%
14	1.3.3	Төсвийн ерөнхийлөн Захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавьж, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангуулна.		Тухайн жилд оруулах мэдээний тоо	171	171	Байгууллагын хэмжээнд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулж нийт 171 мэдээ мэдээлэхээс, хугацаа болоогүй 22, хугацаандаа мэдээлсэн 147, хугацаа хоцорсон 2 мэдээ байна. Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 45 тоот албан бичгээр ерөнхий Нягтлан бодогч Н.Буянхилигт Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайржуулах чиглэлээр албан даалгавар хүргүүлж, хэрэгжилтийг хянан ажилласан.	90%
ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:								
15	2.1	Төрийн албан хаагчийн сургалт ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр		Хэрэгжилтийн хувь	100	100	Тайлант хугацаанд НЗДТГ-с зохион байгуулсан 15 удаагийн сургалтад, давхардсан тоогоор 67 албан хаагч хамрагдсан.	100%

1	2	3	4	5	6	7	8	9
		боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллана. батлуулж					Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.	
16	2.2	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж ажиллана.		Зохион байгуулсан ажлын тоо	4	5	"Жендэрийн эрх тэгш байдлыг хамгаалах" төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Монгол улсын засгийн газар, Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан "Харилцан хүндэтгэе" аяны хүрээнд пост бэлтгэж ERP системд оруулсан. Захиргаа, удирдлагын албаны даргын баталсан удирдамжийн дагуу Тохижилт үйлчилгээний албаны нийт ажилтан албан хаагчдад ХАБЭАТухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм, журамтай холбоотой сургалт, заавар зөвлөгөө өгөх Хуулийн зөвлөх, Хүний нөөц, Ерөнхий нягтлан нартай хамтарсан нэг өдрийн сургалт хийж ажиллав.	70%
17	2.3	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, бодлолын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулж дээд шатны байгууллагад тайлагнана.		Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	2	4	2025 оны албаны болон байгууллагын эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллав. Нийт 5 зорилт, 33 арга хэмжээнд үнэлгээ хийв. Үнэлгээгээр 78.04%-тай /үр дүн хүлээгдэж байна/ үнэлгээ өгөв. Газрын 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг дараагийн улиралд багтаан хийж хэрэгжүүлэх зөвлөмжийг өгч ажилласан.	100%

1	2	3	4	5	6	7	8	9
							Тайлант хугацаанд байгууллагын ажилтнуудын ажлын цаг ашиглалтын байдалд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Нийслэлийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн 10-н үүрэг даалгаврын хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ERP Ulaanbaatar системийн Хяналт шинжилгээ цэсэд оруулан тайлагнасан.	
18	2.4	Баримт нягтлан шалгах комиссын үйл ажиллагааг тогтмолжуулах, байгууллагад Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлаж, мөрдүүлэх, 2024 оны архивын баримтыг хуваарийн дагуу хүлээн авах, нөхөн бүрдүүлэлт хийнэ.		Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын хэрэгжилтийн хувь, баримтын тоо	100	100	Газрын даргын 2025 оны А/19 дугаар тушаалаар байгууллагын Баримт нягтлан шалгах комиссыг шинэчлэн байгуулсан. Тайлант хугацаанд комисс нь нийт 6 удаа хуралдаж, хуралаас гарсан 10 үүрэг даалгаварыг 90%-тай хэрэгжүүлсэн. 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 43 баримтыг архивт хүлээн авсан. "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууды архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд урьдчилсан үзлэг зохион байгуулах тухай" удирдамжийн дагуу 2020-2024 оны архив, албан бичиг хөтлөлтийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах албан шаардлагын дагуу Баримт нягтлан шалгах комисс нь "ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг ханган ажилласан."	90%

1	2	3	4	5	6	7	8	9
							Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэж газрын даргын А/35 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.	
19	2.5	Байгууллагын дэргэдэх өмч хамгаалах зөвлөлийг улиралд 1 удаа хуралдуулж шаардлагатай үед хяналтын тооллого хийх, гарсан шийдвэрийг тухай бүрт нь танилцуулж тайлагнана.		Хурлаар шийдвэрлэсэн асуудлын тоо	4	4	Газрын даргын 2025 оны А/19 тушаалаар байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-г шинэчлэн байгуулсан. Байгууллагын дэргэдэх өмч хамгаалах зөвлөл нь тайлант хугацаанд 4 удаа хуралдаж хурлаас гарсан шийдвэрийг тухай бүрт газрын даргад танилцуулан Нийслэлийн Өмчийн харилцааны газарт 2 албан бичиг хүргүүлж ажилласан.	100%
20	2.6	2025 оны байгууллагын Бизнес төлөвлөгөө гаргаж батлуулан хэрэгжилтийг зохион байгуулна.		хэрэгжилтийн хувь	90	100	2025 оны байгууллагын бизнес төлөвлөгөөг Стратегийн үндсэн зорилтууд хүрэх үр дүн, Байгууллагын 2025 оны зорилт, төлөвлөлт, Маркетингийн төлөвлөгөө, Хяналтын механизм, Санхүүгийн төлөвлөгөө гэсэн дэд бүлгүүдэд хуваан боловсруулж газрын даргаар батлуулсан. Бизнес төлөвлөгөөг 235,2 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд III-р улирлын байдлаар нийт 343,692,300 саяын түрээс үйлчилгээнээс орлого бүрдүүлэн 46%-аар давуулан ажилласан.	100%
21	2.7	Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг зохион байгуулж, архив, албан		Гарсан зөрчлийн тоо	5	0	Газрын даргын 2025 оны А/05-дугаар тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн баталсан.	100%

1	2	3	4	5	6	7	8	9
		хэрэг хөтлөлтийг журмыг мөрдлөг болгон ажиллана.					"Хөдөлмөрийн дотоод журам"-ыг нийт албан хаагчид болон шинээр ажилд орсон албан хаагчдад танилцуулсан. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд Захиргаа, удирдлагын алба хяналт тавин ажилласан тайлант хугацаанд гарсан зөрчил байхгүй. Баримт бичгийг хүлээн авах, шуурхай хянан шийдвэрлэх, цахим албан хэрэг хөтлөлтийн талаарх бодлого стандарт журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. www.egr.ulaanbaatar.mn програмаар тайлант хугацаанд 188 албан бичиг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэн ажилласан. Мөн хугацаанд 162 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу төлөвлөн боловсруулж холбогдох байгууллага албан тушаалтан, хэлтэс албадад илгээсэн.	
22	2.8	Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага MNS6395:2022 стандартын дагуу албан хэргийг крилл болон үндэсний хос бичгээр хөтлөж хэвших,		Монгол бичгээр хөтөлсөн албан бичгийн тоогоор	-	100	Албан бичгийг MNS6395:2022 стандартын дагуу крилл болон үндэсний хос бичгээр хөтөлж хэвшүүлэн ажиллаж байна. Албан хаагчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх талаар арга хэмжээг оруулж баталсан. 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр НЗДТГ-аас зохион байгуулагдсан "Албан хэргийг хос бичгээр хөтлөх" тухай сургалтад байгууллагын 12 албан хаагч хамрагдсан.	100%

1	2	3	4	5	6	7	8	9
23	2.9	Албан хаагчид, иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем ERP-Д бүртгэх, хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнана.		Зөрчилгүй шийдвэрлэсэн өргөдлийн тоо	13	0	Тайлант хугацаанд тус байгууллагын ERP системд нийт 22 өргөдөл, гомдол, хүсэлт ирсэн. Үүнээс 21 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн, 1 өргөдөл, гомдлыг судлаж байна.	100%
24	2.10	Монгол Улсын Засгийн газраас "2025 оныг нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд холбогдох талуудтай уялдааг хангаж, шуурхай хамтран ажиллана.		Хэрэгжилтийн хувь	-	100	Нийслэлийн Засаг даргын "Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалт зохион байгуулах тухай" 2025 оны А/33 дугаар захирамжийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 18, 19-ны өдрүүдэд тус байгууллагын 23 албан хаагчид СБД-н 11-р хорооны гэр хорооллын айл өрхийн зуухны судалгааг хийж, өрхүүдийн мэдээллийг бүртгэлийн системд шивж орлуулсан.	100%
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:								
25	3.1	"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулна.		Хэрэгжилтийн хувь	100	100	"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлын хүрээнд шаардлагатай үйл ажиллагааны бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган төсвийг тооцоолон ажлын хэсэгт санал хүргүүлэн төсөв батлуулж бэлтгэл ажил хангадан ажилласан. "Үндэсний их баяр наадам", "Хүрээ цам-Даншиг наадам"-ын баярын өдрүүдэд Хүй долоо худагт ажиллах	100%

1	2	3	4	5	6	7	8	9
							албан хаагчдын хариуцан хийх ажил үүрэг болон цагийн хуваарийг батлуулж ажиллав. Мөн баяр наадмын өдрүүдэд албадын даргаар ахлуулсан Ерөнхий эргүүл хийх ажлын төлөвлөгөө, хуваарийг батлуулж батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллав.	
26	3.2	"Монгол хүү" "Эрүүл иргэн-Эко хөгжил" спорт өдөрлөг, "Хөхүүрийн айрагны баяр", "Цасны баяр" арга хэмжээнүүдийг зохион байгуулна.	104.0	Арга хэмжээний тоо	3	4	"Монгол хүү" хүүхдийн баярын арга хэмжээг "Хаан Хан-Уул дүүргийн Скаутын холбоо" ТББ-тай хамтран 6 сарын 1 өдөр Хүй долоон худаг дах наадмын талбайд зохион байгуулсан. Үндэсний ёс зан заншлийг хүүхэд залууст сурталчлан таниулах зорилготой тус арга хэмжээний үеэр хүүхдийн үндэсний бөхийн барилдаан, сурын харваа, шагайн харваа, дугуйн тэмцээн, гүйлтийн тэмцээн, хүүхдийн сагсан бөмбөгийн тэмцээн зэрэг спортын олон арга хэмжээ зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд 50 гаруй аж ахуй нэгж байгууллага болон давхардсан тоогоор 7000 гаруй эцэг эх, хүүхэд багачууд оролцсон. "Айрагны баяр" нэгдсэн арга хэмжээг 2025 оны 09-р сарын 19, 20-ний өдрүүдэд ХУД-ын скаутын холбоо, малчидтай хамтран амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээг 3 үе шаттай зохион байгуулсан. Үүнд: 1. Адуу тамгалах ёс 2. "Айргийн баяр-2025" сургалт/нээлт/ 3. "Айргийн баяр-2025" нэгдсэн цугларалт /Хаалт/ гэсэн 3 хэсгээр	100%

1	2	3	4	5	6	7	8	9
							бүрдсэн арга хэмжээ зохион байгуулсан. Хаалтын нэгдсэн арга хэмжээг Сүхбаатар дүүргийн бэлхийн хиймэл нууранд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд нийслэлийн 1800 гаруй сурагчид хамрагдсан. "Эрүүл иргэн-Эко хөгжил" арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгасан. Хугацаа болоогүй байна. /спортын арга хэмжээ, цасны баяр гэх мэт/	
27	3.3	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдтэй хамтран олон нийтэд зориулсан соёл, спорт, аялал жуулчлалын арга хэмжээг зохион байгуулна.		Хамрагдсан иргэдийн тоо	23,000	24,000	2025 оны 18-н арга хэмжээг Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдтэй хамтран зохион байгуулсан байна. Үүнээс 2025.02.21-н, 03.13-нд Монголын морин тойруулга, богино зайн уралдаан, уяачдын холбооны Mongolian breeders cup-2025 тэмцээн 2025.03.27-ны өдөр НЗДТГ-н захирамжаар Хүй долоон худагт Нийслэлийн аварга шалгаруулах "Адуучин" тэмцээн, 2025.05.03-нд "Хангарьд" хаврын морин уралдаан, 2025.05.04-нд, Эрлийз дааганы уралдаан, 2025.05.17-нд Автобус 3 нэгтгэлийн Уран жолоодлогын ур чадварын тэмцээн, 2025.05.25-нд Морь хурдан уу? Дугуй хурдан уу? тэмцээн, 2025.06.07.08-нд Талын салхи мото фестиваль,	100%

1	2	3	4	5	6	7	8	9
							2025.07.18-нд Авто тээврийн 100 жил, 2025.09.05-ны өдөр Дуатлон 2025 арга хэмжээнүүд тус тус зохион байгуулагдаж 30,000 гаруй иргэн оролцсон.	
28	3.4	"Монгол наадам үндэсний спорт цогцолбор"-ын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөний дагуу төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төслийг эхлүүлэхээр холбогдох эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.		Уламжилсан төслийн тоо	1	2	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 99 дүгээр тогтоолоор "Монгол наадам үндэсний спорт цогцолбор"-ийн хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн баталсан. 2025 оны 04 дүгээр сарын 29 ний өдөр ХОТ ТӨЛӨВЛӨЛТ СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ-т "Цэнгэлдэх хүрээлэн", "Сурын харвааны цогцолбор", "Морь барианы хэсэг" болон дагалдах бүтээн байгуулалтын ажлын хөрөнгө оруулалтын эдийн засгийн томсгосон тооцооллыг шинэчлэн хийсэн. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд Монгол наадам үндэсний спорт цогцолборын Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан бүтээн байгуулалтын нийт 11 төсөл арга хэмжээнд 24 тэрбум 94 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг тусгуулахаар саналаа хүргүүлэв.	100%
29	3.5	Байгууллагын цахилгаан хангамжийн хэвийн, найдвартай байдлыг хангах талаар арга хэмжээ авч ажиллана.		Хийгдсэн ажлын тоо	1	6	Хүй долоон худаг дах Монгол наадмын хашаан дах эвдрэлтэй шугам сүлжээг Мобиком үүрэн телефони ХХК-тай хамтран шинэчлэн засварлаж дууссан.	100%

1	2	3	4	5	6	7	8	9
							Хүй долоон худаг дах А,Б талбайд байрлалтай 64 ширхэг гэрэлтүүлгийг шинээр сольсон.	
30	3.6	"Монгол Наадам Цогцолбор" ОНӨТҮГ-ын Улсын тусгай хэрэгцээний 11.089га газрыг арчлах, хамгаалах, ашиглах журам боловсруулан батлуулж, мөрдөж ажиллана.		Батлуулсан журмын тоо	1	1	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу байгууллага дотооддоо журмын төслийг боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
31	4.1	Хотын хөгжлийн Хүртээмжтэй байдал (0.488) индексийн Соёлын хүртээмж (56) индексийг сайжруулах ажлын хүрээнд төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг хангаж ажиллана.		Арга хэмжээний тоо	3	3	Хотын хөгжлийн индексийг сайжруулах зорилтын хүрээнд төрийн бус байгууллагуудтай хамтран 1."Монгол хүү 2025" үндэсний хүүхдийн баяр, 2."Үндэсний их баяр наадам", 3."Даншиг наадам Хүрээ цам", 4. "Айрагны баяр" зэрэг соёлын арга хэмжээнүүдийг Хүй долоон худагт зохион байгуулсан.	100%
ТАВ."ТОХИЖИЛТ-БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ЖИЛ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД								
32	5.1	Хүй долоон худгийн Хурдан морины уралдааны талбайд олон нийтэд зориулсан Тохижилт, бүтээн байгуулалтын ажлыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.		Тохижилтын ажлын тоо	1	2	Монголын морин спорт, уяачдын холбоотой хамтран Улсын их баяр наадмаар барианд орж айрагдсан морьдын хашааг шинээр хийж, мод тарьж тохижуулсан.	100%
33	5.2	Байгууллагын эзэмшлийн экобусны зам, явган хүний зам, морь барианы хэсэг орчмын засвар, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулна.		Хийгдсэн ажлын тоо	1	2	Байгууллагын эзэмшлийн 2,7 км экобусны зам, явган хүний зам, морь барианы хэсэг орчмын арчлалт, засвар хамгаалалтыг сайжруулах ажлыг Нийслэлийн замын хөгжлийн газрын баруун бүсийг хариуцсан хэлтэстэй хамтран засварлуулсан.	100%

1	2	3	4	5	6	7	8	9
Дундаж хувь								92.9% Бүрэн хангал ттай

ХЯНАСАН:
ДАРГА

[Signature]

Д.ОТГОНБААТАР

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН
ТОГТООЛ, ШИЙДЭЭР, ДОТООДЛАХИЙ
ХАРИУЦСАН МЭРТЭЖИЛТЭН



Р.СОЛОНГО

[Signature]

2025 оны.....сарын.....